



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/28

Мөрөн сум

**Гүйцэтгэх захирлын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шишгэд харгуй” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбын Батжаргалыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс чөлөөлж, Цэгмидийн Зоригтыг томилсугай.

2. Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригттой онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр)-д даалгасугай.

3. Компанийн гүйцэтгэх захирлын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээлцүүлж холбогдох баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр)-т даалгасугай.

4. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг батлуулж ажиллахыг “Шишгэд харгуй” ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Зоригт)-д үүрэг болгосугай.

5. Тогтоолыг эс зөвшөөрвөл хувьцаа эзэмшигчдийн хурал болон шүүхэд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ПҮРЭВДОРЖ

